



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/078/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2026 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .	Error! Bookmark not defined.
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн	Error! Bookmark not defined.
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026-02-05 № 301

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ө.ЦЭВЭЭНСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

2125020272

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 4 зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг 78.6 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	431,915,493.06	425,016,567.42
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	308,451,275.39	280,768,150.52
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	308,451,275.39	280,768,150.52
31211	Төрийн сангийн харилцах	308,451,275.39	280,768,150.52
33	АВЛАГА	1,531,587.64	-
335	Бусад авлага	1,531,587.64	-
33510	Байгууллагаас авах авлага	1,531,587.64	-
35	БАРАА МАТЕРИАЛ	121,932,630.03	144,248,416.90
351	Түүхий эд материал	19,729,631.67	18,118,818.54
35110	Тусгай зориулалттай материал	18,771,131.67	17,160,318.54
35130	Эм боох материал	958,500.00	958,500.00
354	Хангамжийн материал	102,202,998.36	126,129,598.36
35420	Аж ахуйн материал	60,127,804.16	72,927,804.16
35470	Бусад хангамжийн материал	42,075,194.20	53,201,794.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,049,083,774.27	2,037,704,111.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,049,083,774.27	2,037,704,111.51
392	Биет хөрөнгө	2,003,315,774.27	1,991,936,111.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,035,948,957.65	2,035,948,957.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(262,525,635.00)	(324,445,981.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	169,716,043.00	268,040,843.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(59,968,846.44)	(97,001,981.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,104,957.62	130,074,957.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,996,747.18)	(46,196,680.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	139,918,392.00	139,918,392.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(110,671,345.88)	(117,192,393.68)
39217	Ном	2,789,998.50	2,789,998.50
393	Биет бус хөрөнгө	45,768,000.00	45,768,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	45,768,000.00	45,768,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,480,999,267.33	2,462,720,678.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,268,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,268,000.00	-
413	Өглөг	10,268,000.00	-
4136	Бусад өглөг	10,268,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	10,268,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,470,731,267.33	2,462,720,678.93
51	Засгийн газрын хувь оролцоо	2,470,731,267.33	2,462,720,678.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	411,893,287.87	411,893,287.87
51101	Өмч: - төрийн	411,893,287.87	411,893,287.87
512	Хуримтлагдсан үр дүн	1,634,116,934.37	1,626,106,345.97
51210	Өмнөх үеийн үр дүн	1,004,048,802.62	1,634,116,934.37
51220	Тайлант үеийн үр дүн	630,068,131.75	(8,010,588.40)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	424,721,045.09	424,721,045.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,480,999,267.33	2,462,720,678.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,906,335,701.60	1,523,540,166.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	652,799,301.60	130,035,166.90
120	Нийтлэг татварын бус орлого	652,799,301.60	130,035,166.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	414,035,781.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	414,035,781.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	216,445,905.40	104,703,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	22,317,615.20	25,332,166.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,253,536,400.00	1,393,505,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,186,732,600.00	1,330,115,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,186,732,600.00	1,330,115,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,403,800.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,403,800.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,400,000.00	63,390,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,400,000.00	63,390,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,276,163,369.70	1,531,550,755.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,276,163,369.70	1,531,550,755.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,231,607,144.68	1,463,065,128.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	868,930,542.11	1,066,745,104.39
210101	Үндсэн цалин	561,208,476.08	659,877,468.10
210102	Нэмэгдэл	279,220,177.33	343,014,171.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,470,000.00
210104	Урамшуулал	28,501,888.70	30,383,465.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,386,169.42	127,802,887.72
210201	Тэтгэврийн даатгал	73,280,503.86	88,087,994.02
210202	Тэтгэмжийн даатгал	8,461,879.05	10,491,950.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,251,244.12	6,284,893.25
210204	Ажилгүйдлийн даатгал	3,950,535.06	4,759,670.06
210205	Эрүүл мэндийн даатгал	16,442,007.33	18,178,379.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,607,052.80	52,983,682.00
210301	Гэрэл, цахилгаан	8,999,752.80	23,413,332.00
210302	Түлш, халаалт	39,123,800.00	27,470,350.00
210303	Цэвэр, бохир ус	2,483,500.00	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,996,855.00	3,716,380.03
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,996,855.00	
210408	Бараа материал акталсны зардал		3,716,380.03
2105	Нормативт зардал	25,034,455.29	36,102,795.40
210502	Хоол, хүнс	25,034,455.29	36,102,795.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,399,094.00	9,000,000.00
210604	Урсгал засвар	10,399,094.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,201,490.85	18,370,694.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,586,890.85	18,370,694.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,051,485.21	148,343,584.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,629,333.99	21,048,573.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,795,720.00	6,620,549.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,626,431.22	120,674,462.76

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,556,225.02	68,485,626.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,257,071.82	67,479,309.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,257,071.82	67,479,309.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	299,153.20	1,006,317.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	299,153.20	1,006,317.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	630,172,331.90	(8,010,588.20)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	104,200.16	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	104,200.16	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(104,200.16)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	630,068,131.74	(8,010,588.20)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,253,536,400.00	1,393,505,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,253,536,400.00	1,393,505,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,186,732,600.00	1,330,115,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,186,732,600.00	1,330,115,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,403,800.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,403,800.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,400,000.00	63,390,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,400,000.00	63,390,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,161,858,334.91	1,421,188,124.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,161,858,334.91	1,421,188,124.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,119,458,311.81	1,351,963,743.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	870,462,129.75	1,065,213,516.75
210101	Үндсэн цалин	562,740,063.72	658,345,880.46
210102	Нэмэгдэл	279,220,177.33	343,014,171.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,470,000.00
210104	Урамшуулал	28,501,888.70	30,383,465.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,386,169.42	127,802,887.72
210201	Тэтгэврийн даатгал	73,280,503.86	88,087,994.02
210202	Тэтгэмжийн даатгал	8,461,879.05	10,491,950.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,251,244.12	6,284,893.25
210204	Ажилгүйдлийн даатгал	3,950,535.06	4,759,670.06
210205	Эрүүл мэндийн даатгал	16,442,007.33	18,178,379.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,607,052.80	53,383,682.20
210301	Гэрэл, цахилгаан	8,999,752.80	23,413,332.20
210302	Түлш, халаалт	39,123,800.00	27,470,350.00
210303	Цэвэр, бохир ус	2,483,500.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	23,742,925.00	35,364,040.40
210502	Хоол, хүнс	23,742,925.00	35,364,040.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,493,794.00	9,000,000.00
210604	Урсгал засвар	10,493,794.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,201,490.85	18,370,694.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,586,890.85	18,370,694.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,564,749.99	42,828,922.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,780,629.99	36,040,373.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,784,120.00	6,788,549.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,400,023.10	69,224,381.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,100,869.90	68,218,064.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,100,869.90	68,218,064.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	299,153.20	1,006,317.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	299,153.20	1,006,317.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	91,678,065.09	(27,683,124.87)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	91,678,065.09	(27,683,124.87)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	216,773,210.30	308,451,275.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	308,451,275.39	280,768,150.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	1,004,048,802.62	1,840,663,135.58
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн	-	-	630,068,131.75	630,068,131.75
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	1,634,116,934.37	2,470,731,267.33
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	1,634,116,934.37	2,470,731,267.33
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн	-	-	(8,010,588.40)	(8,010,588.40)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	1,626,106,345.97	2,462,720,678.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	308,451,275.39	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,653,160,300.00	1,357,798,124.87	295,362,175.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,653,160,300.00	1,357,798,124.87	295,362,175.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,579,661,700.00	1,289,580,060.87	290,081,639.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,303,231,700.00	1,065,213,516.75	238,018,183.25
210101	Үндсэн цалин	812,095,300.00	658,345,880.46	153,749,419.54

210102	Нэмэгдэл	479,020,400.00	376,484,171.23	102,536,228.77
210104	Урамшуулал	12,116,000.00	30,383,465.06	(18,267,465.06)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,904,000.00	127,802,887.72	35,101,112.28
210201	Тэтгэврийн даатгал	110,774,700.00	88,087,994.02	22,686,705.98
210202	Тэтгэмжийн даатгал	13,032,300.00	10,491,950.40	2,540,349.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,516,200.00	6,284,883.25	231,316.75
210204	Ажилгүйдлийн даатгал	6,516,200.00	4,759,670.06	1,756,529.94
210205	Эрүүл мэндийн даатгал	26,064,600.00	18,178,389.99	7,886,210.01
2105	Нормативд зардал	36,613,000.00	35,364,040.40	1,248,959.60
210502	Хоол хүнс	36,613,000.00	35,364,040.40	1,248,959.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,918,300.00	18,370,694.00	2,547,606.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	20,918,300.00	18,370,694.00	2,547,606.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,994,700.00	42,828,922.00	13,165,778.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,203,400.00	36,040,373.00	13,163,027.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,791,300.00	6,788,549.00	2,751.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,498,600.00	68,218,064.00	5,280,536.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,498,600.00	68,218,064.00	5,280,536.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	73,498,600.00	68,218,064.00	5,280,536.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,653,160,300.00	1,357,798,124.87	295,362,175.13
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,653,160,300.00	1,357,798,124.87	295,362,175.13
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,653,160,300.00	1,357,798,124.87	295,362,175.13
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	280,768,150.52	-

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,840,000.00	62,383,682.20	5,456,317.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,840,000.00	62,383,682.20	5,456,317.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,840,000.00	62,383,682.20	5,456,317.80
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	67,840,000.00	62,383,682.20	5,456,317.80
210301	Гэрэл, цахилгаан	27,500,000.00	23,413,332.20	4,086,667.80
210302	Түлш халаалт	28,840,000.00	27,470,350.00	1,369,650.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,500,000.00	0.00
210604	Урсгал засвар	9,000,000.00	9,000,000.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	67,840,000.00	62,383,682.20	5,456,317.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,840,000.00	62,383,682.20	5,456,317.80
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,840,000.00	62,383,682.20	5,456,317.80

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 117.1 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 2 зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 13,524 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9,448.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв.

5.1 Албан шаардлага

1. Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэж заасантай нийцэхгүй байна.
2. Худалдан авах ажиллагааны, үнэлгээний хорооны тэмдэглэл дээр тендер зарласан эсэх шийдвэр байхгүй, хүнсний материал худалдан авах гэрээг байгуулахдаа нийлүүлэх хүнсний барааны жагсаалт, нэгжийн үнийг хавсаргаагүй, тухайн багцын төсөвт өртгийг /гэрээний үнэ/ гэрээнд тусгаагүй, гэрээ дүгнэсэн актыг буруу үйлдсэн, тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.1-д Гэрээний үнэ, 39.3.2-т Гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, 48 дугаар зүйлийн 48.4.6-д Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл зөвлөмж, НББ тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно, 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэснийг мөрдөөгүй байна.
3. Өмнөх аудитаар илэрсэн худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлийг давтан гаргасанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой

Илрүүлэлт: Шилэн дасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг цаг тухайд нь мэдээллэх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан	1	13,524.6			1	13,524.6							
Өмнөх оны аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой албан шаардлага хүргүүлж байсан алдаа зөрчлийг давтан гаргасан байна.									1	1			
Дүн	2	13,524.6			1	13,524.6			1	1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны, худалдан авах ажиллагааны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 10 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй байна.	1	-						1	-
Худалдан авах ажиллагааны, үнэлгээний хорооны тэмдэглэл дээр тендер зарласан эсэх шийдвэр байхгүй, хүнсний материал худалдан авах гэрээг байгуулахдаа нийлүүлэх хүнсний барааны жагсаалт, нэгжийн үнийг хавсаргаагүй, тухайн багцын төсөвт өртгийг /гэрээний үнэ/ гэрээнд тусгаагүй, гэрээ дүгнэсэн актыг буруу үйлдсэн, тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн	1	103,582.1					1	103,582.1	
Нийт дүн	2	103,582.1					1	103,582.1	1